

АНУ-ЫН УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦОО

Д.Цолмон
(дэд эрдэмтэн)

Аливаа улс гүрний улс төрийн тогтолцоо буюу байгуулалт нь тухайн орны төр засаг, нийгмийн байгууллын шинж чанарыг тодорхойлдог өргөн агуулгатай асуудал юм. АНУ-ын судлаач У.Андерсон улс төр судлалын шинжлэх ухааны судлах зүйл нь улс төрийн тогтолцоо агаад "Нийгмийн улс төрийн бодлогыг бүрэлдүүлэн хэрэгжүүлэхэд чиглэсэн нийгмийг хамарсан иж бүрэн өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа"-г улс төр судлал гэж тодорхойлсон байдаг.

Улс төрийн байгуулалт америкийн хувьсгал ялж тусгаар тогтнолоо байлдан олж үндсэн хуулиа баталсан үеэс бүрэлдэн тогтсон ажээ.

ХҮШ дугаар зууны далаад онд "Америк дахь Английн колониуд, эзэн гүрний хоорондын зөрчил хурцдаж америкчууд шинэ нутагтаа өөрсдөө төр улсаа засан тохиуулах, гадаад ертөнцтэй бүрэн эрхтэй харилцах зорилтоо хэрэгжүүлж эхлэсэн билээ. 1775 оны хавар Филадельфид ажлаа эхэлсэн "Эх газрын колониудын оршин суугчдын төлөөлөгчдийн П их хурал" Английн колончлолоос ангижирч биеэ дааж хөгжих асуудлыг авч хэлэлцээд "Тусгаар тогтнолын Тунхаглал" боловсруулан гаргах болов. Соён гэгээрүүлэгч, улс төрийн нэрт зүтгэлтэн Томас Жефферсон тэргүүтэй хорооны боловсруулсан энэхүү Тунхаглал нь тусгаар тогтнолыг төрийн байгууламжийн үндсэн суурь болгон авч үзсэн түүхэн баримт бичиг юм. Уг тунхаглалд Английн хаант Засгийн дээрэнгүй үзэл, хүний наад захын эрхийг зөрчиж америкчуудыг зүйл бүрээр хавчиж буйг буруушааж ард түмэн бүр хувь заяагаа өөрсдөө шийдвэрлэж байх эрхтэй болохыг дурджээ.

Умард Америк дахь Английн колониуд ийнхүү эрх чөлөөтэй тусгаар тогтносон улс болж, энх тайвнаар аж төрөх, арилжаа худалдаа эрхлэх зэрэг бүхий л эрхийг өөрсдөө эдлэнэ гэдгээ дэлхий дахинд зарлан тунхагласан байна.

"Аз жаргалын төлөө тэмүүлэх" хүний эрхийн асуудал тусгаар тогтнолын Тунхаглалын голт зүрх нандин хэсэг гэж улс төр судлаачид тайлбарладаг.

Ийнхүү бүгд найрамдах улсын төрийн байгуулалтын үндсийг ардчилалын үндсэн дээр бүрэлдүүлэх үзэл санаа уг түүхэн баримт бичигт тусгалаа олжээ.

1787 оны 5 дугаар сард Филадельфид цугларсан штатуудын төлөөлөгчдийн их хурал үндсэн хуулийн конвенц нэртэйгээр хуралдаж 1781 онд боловсруулан гаргасан "холбооны зүйл анги" гэдэг баримт бичгийг дахин хянан засварлах ажилд орсон юм. Уг баримт бичигт гадаадын дайсгагналын эсрэг штатууд үйл ажиллагаагаа нэгтгэх тухай дурдсан байсан юм.

Энэхүү хурал 18 долоо хоног үргэлжилж үндсэн хуулийг боловсруулан гаргасан түүхтэй. Их хурал америкийн төр, засгийн хэлбэр, түүний зохион байгуулалт, өмчийн хэлбэр, иргэдийн эрх, хууль тогтоох, засаглалын харилцан уялдаа, хяналт зэрэг өргөн цар хүрээтэй асуудлыг үндсэн хуульд тусгахаар шүүн хэлэлцжээ.

1787 он 9 дүгээр сарын 17-нд 12 штатын төлөөлөгчид үндсэн хуулийн төсөлд гарын үсэг зурж мөн сарын 28-нд конгресс уг хуулийг зөвшөөрч штатуудын хууль тогтоох байгууллагуудад танилцуулахаар тогтсон юм.

Америкийн нийгмийн цаашдын хөгжлийн төлөвийг хуульчлан тогтоож өгсөн энэхүү үндсэн хуулийг батлах явцад нэг хэсэг нь төвлөрсөн хатуу засаглалын төлөө, нөгөө хэсэг нь штатуудын өргөн эрхийг хамгаалсан байр сууринаас хандаж байв. Энэ хоёр чиг, хандлага федералист, антифедералист хэмээх 2 урсгалд багтсан ажээ.

Федералистуудыг томоохон газар эзэмшигчид, мөнгө хүүлэгчид, гар урчуудын хэсэг дэмжиж байсан бол антифедералистууд төвлөрсөн хатуу засаглалын эсрэг ардчилсан эрх чөлөөг хуульчлан бататгах талд зогсож байлаа. Үндсэн хуулийг боловсруулан хэлэлцэх явдал хүний үндсэн эрхийн асуудал хамгийн маргаантай зүйл байсан бөгөөд олонхи муж улсуудын төлөөлөгчид америкийн улс төрийн нэрт зүтгэлтэн Томас Жефферсон тэргүүтэй хувьсгалчдын боловсруулсан "эрхийн тухай хууль"-ийг үндсэн хуульд нэмэлт болгон тусгах нь зүйтэй гэж үзжээ.

АНУ-ын үндсэн хуульд иргэдийн үг хэлэх, хэвлэн нийтлэх, шүтэх бишрэх эрх, хувийн эрх чөлөөг хамгаалах, тухайлбал иргэдийн өмч хөрөнгө, орон сууц болон бичиг баримтанд үндэслэлгүй нэгжлэг хийхийг хориглох тухай зааж өгчээ.

АНУ-ын Үндсэн хууль бол хүн төрөлхөтний түүхэн дэхь анхны бичмэл үндсэн хуулиудын нэг мөн.

1787 оны 9 сарын 17-нд Филадельфийн конвенцоор баталсан үндсэн

хуулийг 1789 онд конгресс авч хэлэлцээд 12 нэмэлтийг зөвшөөрч штатуудад батлуулахаар илгээсэн ажээ. Зарим хуульч, эрдэмтэд 1787 оны "Холбооны улсын зүйл ангийг" Америкийн анхны үндсэн хууль гэж үзэх нь зүйтэй гэсэн саналтай байдаг. Холбооны улсын анхны Үндсэн хууль батлагдснаас хойш магтан сөйшөөх, шүүмжлэн хэлэлцэх олон янзын тайлбар өгч иржээ. АНУ-ын үндсэн хууль 200 гаруй жилийн турш үйлчлэхдээ бусад улсын үндсэн хуулийг бодвол харьцангуй бага өөрчлөгджээ. Энэ үндсэн хууль хуучин Английн колониудын оронд бий болсон холбооны шинэ улсын засаг төрийн механизмыг бүрдүүлэхэд хийсэн том алхам юм. АНУ-ын Үндсэн хууль чь дэлхийн соёл иргэншлийн, улс төрийн судлалын санд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан түүхэн баримт бичиг юм. Энэхүү хуульд өөрийнхөө зууныг алгасан түрүүлсэн, үнэхээр тэргүүний үзэл бодол, санаа тусгагдсан байна. Үүнд:

- хуулийн өмнө иргэн бүр тэгш эрх өдлөх,

- улс төрийн олон ургальч үзэл,

- иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөө,

- бүгд найрамдах хэлбэрийн зарчим гэх мэт тухайн үеийн улс төрийн шинэ ойлголтыг уг хуульд багтаажээ.

Америкийн Үндсэн хуульд Умард Америкийн иргэд өөрсдийгөө нэгдмэл нэгэн үндэстэн-америкчууд гэдгээ аажмаар ухамсарлан ойлгох, үндэсний ухамсар бүрэлдэн тогтоход эерэг нөлөө үзүүлсэн ажээ.

АНУ-ын үндсэн хуулийн оршилд Америкийн ард түмэн эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, аюулгүй байдал, өөрсдийн болон хойч үеийнхээ сайн сайхан амьдралын баталгаа болгон үндсэн хуулиа зохиосон тухай дурьдаад Америкийн засаг төрийн механизмыг тодорхойлж, төвлөрсөн засагтай, муж улсууд нь харьцангуй өргөн эрхтэй, өрөнхийлөгч бүхий холбооны улс мөн гэж заажээ.

АНУ-ын Үндсэн хууль 7 бүлэг, 21 зүйл анги, 26 нэмэлттэй юм.

Үндсэн хуулийн гол хэсэгт хууль тогтоох, гүйцэтгэн захирах, шүүхийн механизм, бүтэц, эрх дарх, төрийн дээд байгууллагуудад сонгох, сонгогдох зарчим тусгагдсан байна.

Үндсэн хуульд оруулсан анхны 10 нэмэлт өөрчлөлт 1791 онд тусгагдсан ажээ. Эдгээрээс гадна 1971 оныг хүртэл конгресс зөвшөөрч, муж улсууд батлаж нийтдээ 26 нэмэлт өөрчлөлт орсон юм.

Эдгээр нэмэлт өөрчлөлтийн дотор иргэдийн шүтэн бишрэх, хэвлэн нийтлэх, зэвсэг биедээ авч явах, гэр орон, хувийн өмч, бичиг баримтыг нэгжихийг хориглох зэрэг иргэний эрхийн холбогдолтой заалтууд оржээ.

Иргэдэд дааж давшгүй торгууль ноогдуулж барьцаа авах, хэргийгээр залхаан цээрлүүлэхийг үндсэн хуулиар хориглож, АНУ-д боолчлол болон албадлагын хөдөлмөр байж болохгүй гэдгийг зэвжээ.

Америкийн Нэгдсэн улсад төрсөн болон харьяат болсон хүмүүс тус улсын иргэн болно. Ямар ч муж улс тэдний эрхийг хязгаарласан хууль гаргахгүй хэмээн үндсэн хуульд заасан эдгээр интернационалч олон үндэстний шинж чанартай заалтуудын ачаар Америкт аж төрөхөөр очсон үй олон гадаад иргэд тус улсын хүн амын бүрэлдэхүүнд шингэн аж төрсөөр байна.

Төрийн байгуулалт

Үндсэн хуульд АНУ-ын засаг төрийн бүтэц, хэлбэр, холбооны улсын засаглалын механизмыг тодорхойлсон юм. АНУ-ын төр засаг нь 3 үндсэн салбараас бүрэлдэнэ. Үүнд: 1. хууль тогтоох, 2. гүйцэтгэн захирах, 3. Шүүх засаглал болно. Эдгээр гурван салбар үйл ажиллагаагаар харилцан уялдаатай явуулдаг боловч нэг нь нөгөөдөө захирагдахгүй. Өөрөөр хэлбэл нэгд нь байдаггүй эрх дархыг нөгөө нь эдэлдэг, аль нэг нь үндсэн хуульд хэрш хууль бус үйл ажиллагаа явуулбал бусад салбар нь түүнийг хянан үзэж, хазаарлан барьдаг байна.

Үндсэн хуулийн 1 бүлэгт хууль тогтоох дээд байгууллагын тухай заажээ. Тус улсын хууль тогтоох эрхийг сенат болон Төлөөлөгчдийн танхим хоёроос бүрэлдсэн Конгресс эдлэнэ. АНУ-ын сенатад муж улс тус бүрээс 2 сенатор зургаан жилийн хугацаатай сонгогдоно. Тэгэхдээ сүүлийн 9 жил АНУ-ын иргэн байж, 30 нас хүрсэн хүнийг сенаточоор сонгодог байна.

Дэд ерөнхийлөгч Сенатын даргын үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ хэрэв Сенатын хуралдаанд санал хуваагдавал саналаа өгөх эрх эдэлдэг ажээ. Сенатын гишүүдийн гуравны нэг нь хоёр жил тутамд солигдож байдаг уламжлал тогтжээ.

Сенат ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөх, хууль санаачлах, төлөөлөгчдийн танхим аас оруулсан хуулийн төслийг буцааж цуцлах зэрэг өргөн эрх эдэлдэг.

Төлөөлөгчдийн танхимын гишүүнээр штатуудаас хүн амын тоог харгалзан 2 жилийн хугацаагаар суух төлөөлөгчийг сонгоно. Танхимд төлөөлөгчөөр сүүлийн 7 жил тухайн муж улсад аж төрсөн, 25 нас хүрсэн иргэнийг сонгоно. Төлөөлөгчдийн танхимын хуралдааныг спикер даргална. Илтгэгч болон бусад тушаалтнаа Танхимын дотроос сонгон баталдаг ажээ.

Аливаа хуулийг төлөөлөгчдийн танхимд боловсруулан хэлэлцээд Сенатад оруулж зөвшөөрсний дараа ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барина.

Төлөөлөгчдийн танхим холбооны улсын санхүү, төсвийг батлан гаргадаг юм. Эдүгээ АНУ-ын конгрессийн төлөөлөгчдийн танхим 435 гишүүнтэй.

Конгрессийн 2 танхим нийлж хуралдавал Хорооны бага хурал болно. Хоёр танхим хойуулаа зөвшөөрсөн хуулийг ерөнхийлөгчид гарын үсэг зуруулахаар өргөн барина. Хэрэв ерөнхийлөгч батлаж мутарлахгүй бол уг хуулийг оруулсан танхимд нь буцаадаг номтой. Үүний дараа уг хуулийг татгалзсан үндэслэлийн хамт хэвлэн гаргах агаад танхимд гуравны хоёр хувийн санал авбал уг хуулийг хүчинтэйд тооцно (АНУ-ын үндсэн хууль, 7-р зүйл).

АНУ-ын конгрессийн эрх, үүрэгт бүх нийтийн амгалан байдлыг сахин хамгаалах, татварын хэмжээг тогтоох, гадаад улс гүрнүүдтэй харилцах чиг шугамыг тодорхойлох, хууль тогтоомжийг гаргах, түүнийг хэрэгжүүлэх мөнгөн тэмдэгтийн асуудлыг шийдвэрлэх, ноцтой гэмт хэргийг шийдвэрлэх, арми зэвсэгт хүчнийг байгуулах зэрэг улсын чанартай эрх зүйн гол асуудлууд багтдаг.

Конгресс жилд нэг удаа чуулах ба хэрэв ямарваа шалтгаанаар өөрчлөлт орохгүй бол жил бүрийн 12 дугаар сарын эхний долоо хоногийн даваа гаригт ажлаа эхэлдэг юм.

Конгрессийн үйл ажиллагаа нээлттэй явагдах ба батлан хамгаалахаас бусад асуудлыг радио төлөвизээр нэвтрүүлж болно.

Гүйцэтгэх засаглал.

Америкийн нэгдсэн улсын ерөнхийлөгчийг сонгох, түүний эрх дэрх, үүргийг үндсэн хуулийн II бүлэгт заажээ. Тус улсын ерөнхийлөгчийг 4 жилийн хугацаагаар сонгоно. Тэрээр зөвхөн 2 дахь удаа сонгогдож болно. Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нарыг муж бүрээс тусгай сонгогчид гарч Х1 сарын анхны 7 хоногт сонгоно.

35 нас хүрсэн, Америкийн Нэгдсэн Улсын иргэн 14 жил байсан хүн тус улсын ерөнхийлөгч болж болно. Ерөнхийлөгч нас бараас дэд ерөнхийлөгчид шууд түүний эрх мэдэл шилждэг байна. Ерөнхийлөгч өөрөө огцрохыг хүсвээс уг албан тушаалаас татгалзах болсон-тухай өргөдөл бичиж сенатын дарга ба танхимын илтгэгчид өргөн барина. Харин уг өргөдөлөөсөө татгалзаж албаа хашиж чадахав дахин өргөдөл гаргаж илэрхийлж болдог журамтай ажээ.

Ерөнхийлөгчид үл илтгэх, эсвэл ноцтой баримт сэлттэй болсаас конгрессийн танхим дааж заалдаж ерөнхийлөгчийг огцрохыг шаардах эрх эдэлнэ. Ийм тохиолдол АНУ-ын түүхэнд ховор гарч байжээ.

АНУ-ын ерөнхийлөгч нь тус улсын гүйцэтгэх засаглалын тэргүүн зэвсэгт хүчний ерөнхий командлагч юм.

Ерөнхийлөгч сенаттай зөвшилдөн холбооны сайд нар, түүнтэй адилтгах албан тушаалтэн, элчин сайдууд, дээд шүүгчийг томилно. Сенатын зөвлөмж, зөвшөөрлийн үндсэн дээр гадаад орнуудтай гэрээ хэлэлцээр байгуулна. Тэрээр ял шийтгэлийг хойшлуулах, өршөөх эрхтэй.

Тэрээр Америкийн Нэгдсэн улсын албан тушаалтнууд хууль, албан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж ажиллана.

Тус улсын ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, бусад гүйцэтгэн захирах албан тушаалтан эх орноосоо урвах, хээл хахууль авах зэргээр Үндсэн хууль зөрчсөн гэмт хэрэг үйлдвээс албан тушаалаасаа огцрох ёстой.

"Миний бие АНУ-ын ерөнхийлөгчийн албан тушаалд үнэн сэтгэлээр ажиллаж Америкийн Нэгдсэн Улсын үндсэн хуулийг дэмжин хамгаална" гэж тангараглаад цагаан ордонд эзэн болж сууна.

АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулиар зөвхөн төрийн тэргүүн, түүний орлогчийг сонгоод зогсохгүй, сенатын 100 гишүүний 33-ыг, Конгрессийн доод танхим болох төлөөлөгчдийн танхимын гишүүдийг бүхэлд нь сонгодог улс төрийн томоохон үйл явдал болдог юм. Сонгууль анхан шатны сонгууль, намуудын бүлэглэлийн зөвлөлгөөн, намуудын үндэсний конвенц (их хурал) гэх мэт хэд хэдэн үе шаттай явагдаж хамгийн эцэст сонгуулийн коллеж хэмээх байгуулагаар дамжина.

Шүүх засаг.

АНУ-ын улс төрийн системийн бүрэлдэхүүнд шүүх засаг багтана. Дээд шүүх буюу шүүх засаглал үндсэн хууль, улсын бусад гол хууль тогтоомжийн биелэлт, элчин сайдуудын үйл ажиллагаа, цэрэг, зэвсэгт хүчний хэрэг явдал, улс орны аюулгүй байдлын чухал хэрэг, муж улсуудын харилцааг хянаж байдаг. Мөн гадаад орнуудын элчин сайд, консул тус оронд байх хугацаанд тэднийг тус улсын дээд шүүх хариуцна.

Конгрессоор баталсан хууль нь тус улсын үндсэн хуульд харшилбал Дээд шүүх түүнийг хүчингүйд тосгож болно. АНУ-ын дээд шүүх дарга, найман гишүүнээс бүрэлдэнэ. Дээд шүүхийн гишүүдийг ерөнхийлөгчийн зарлигаар насаар нь томилдог ажээ.

АНУ-ын дээд шүүх буюу Холбооны шүүх, түүний салбар тойргийн шүүхүүд ажиллана. Дээд шүүх үндсэн хуулийн биелэлтийн асуудлаар давж

заалдах буюу хэрэг үүсгэх эрх эдэлнэ. Энэ нь үндсэн хуулийн биелэлтийн асуудлаар цэцийн үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг юм.

Ийнхүү үндэсний Засгийн газрын гурван бүрэлдэхүүн хэсэг нь нэг нэгнийхээ үүргийг давхар орон гүйцээтгэхгүй бие даасан, үндсэн хуулийг хэрэгжүүлэхэд нэгд нь байдаггүй эрх, үүргийг нөгөө салбар нь эдэлдэг. Хууль тогтоох салбарт хуулийг боловсруулж, шүүхийн салбар хуулийг тайлбарлаж, хяналт тавьж гүйцэтгэгч салбар нь түүнийг амьдралд хэрэгжүүлэнэ. Аль нэг нь үндсэн хуульд харш үйл ажиллагаа явуулбал түүнийг чөгөө салбар нь хязгаарладаг засаглалын тэнцвэртэй тогтолцоо ийнхүү бүрэлдэн тогтсон байна.

Улс төрийн гол намууд.

Америкийн нэгдсэн улс бол улс төрийн хоёр нам бүхий ерөнхийлөгчийн засаглалтай улс юм. Аливаа улс орныг эрх баригч намын гүйцэтгэж буй үүргээс үүдэн нэг намын, хоёр намын, олон намын тогтолцоотой гэж ангилж үздэг юм. Жишээлбэл: Социалист хэмээгдэж байсан орнуудад гол төлөө нэг намын системтэй байхад АНУ, Англи зэрэг улс оронд 2 нам Засгийн эрхийг ээлжлэн барьсаар байна.

Тус улсын улс төрийн тогтолцоонд чухал үүрэг бүхий Ардчилсан нам, Бүгд Найрамдах нам хоёр үүсэн байгуулагдсны түүх, дэмжигч бүлэглэлүүдийн хувьд түүнчлэн эдийн засгийг удирдах, үйлдвэрлэлийг эрхлэн хөтлөх асуудлаар баримтлах байр суурийн хувьд ялгаатай. Америкийн улс төрийн нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч Томас Жефферсоний үзэл санааг баримтлагчдын бүрдүүлсэн Ардчилсан нам 1828 онд байгуулагдсан ажээ.

Ардчилсан нам анх тулгын чулуугаа тавихдаа өмнөд штатуудын газар эзэмшигч, цагаачлан ирсэн иргэд, умард штатуудын худалдаачид, банкны эздийн дэмжлэгийг авсан ажээ.

Америкийн түүхэнд 42 удаа болсон ерөнхийлөгчийн сонгуулийн 19-д нь Ардчилсан нам ялж байсан байна.

Америкийн түүхэнд Засгийн эрхэнд ерөнхийлөгчөөр 3 удаа сонгогдсон Франклин Делано Рузвельт (1933-1945), Харри Труман (1945-1953), ерөнхийлөгч Жон Кеннеди (1961-1963), Жимми Картер (1977-1981), эдүгээгийн ерөнхийлөгч Билл Клинтон нар ардчилсан намаас дэвшсэн сенаточ нар юм.

Америкчууд Ардчилсан намыг арай илүү либерэл нам гэж үздэг. Ажилчид хөдөлмөрчдийн дээд, дунд давхаргын ашиг сонирхлыг хамгаалсан үйлдвэрчний эвлэлүүдийг түшиглэж нийгмийн хангамжийн асуудлаар сонгогчдын дэмжлэг авсан Ф.Д.Рузвельтийн улс төрийн "шинэ бодлого"

болон гадаад, дотоод бодлогын олон асуудлаар ардчилсан намын байр суурь бэхжиж иржээ.

Гэтэл Бүгд найрамдах намын талаас сүүлийн жилүүдэд нийгэм хангамж, үйлдвэрлэлийн бүсхүрээнд ихээхэн зардал гаргаж үрэлгэн бодлого явуулаа хэмээн Ардчилсан нам шүүмжилж байсан ажээ. Сүүлийн 25 жилд тус намын нэрхүнд байр суурь суларч 2-хон удаа ерөнхийлөгч болсон авч 1992 оны сонгуулиар Билл Клинтон ялалт байгуулав. АНУ-ын шинэ засгийн газар эдийн засгаа хөгжүүлэхэд түлх анхаарч, гадаад бодлогын хувьд ерөнхийлөгч Бушийн баримталж ирсэн чиг шугаманд зарчмын өөрчлөлт гаргахгүйгээр ажиллах үзэл баримтлал дэвшүүлэв.

Бүгд найрамдах нам.

1854 онд байгуулагдсан энэ нам Америкийн улс төрийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэсээр иржээ. Бүгд найрамдах намын талынхөн ерөнхийлөгч Жорж Вашингтон (1789-1797), Жон Адамс (1797-1801) нарыг дэмжиж байсан юм. Бүгд найрамдахчууд умард штатуудын аж үйлдвэрийн хөрөнгөтнүүдийн ашиг сонирхлыг хамгаалж боол эзэмших явдлыг устгах, газар эзэмшлийг өөрчлөн зохион байгуулахын төлөө тэмцэж гарч ирсэн агаад 1860 онд ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан Аараам Линкольн (1861-1865) боолчлолыг үүрд таслан зогсоох, Холбооны нэгдмэл улсыг бэхжүүлэх асуудлаар хатуу байр сууринаас хандаж нэрхүнд олж авч байжээ. Бүгд найрамдах намаас нэр дэвшиж ерөнхийлөгч бологсдын дотор дэлхийн П дайнд нэрд гарсан генерал Д.Эйзенхауэр (1953-1961), Ричард Никсон (1969-1974), Рональд Рейган (1980-1988), Жорж Буш (1988-1992) нарыг өргөн олон уншигчид мэдэх билээ.

Аливаа улс төрийн нам бол Засгийн эрхэнд орж тухайн орны улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралд нөлөө үзүүлэх эрмэлзлэл бүхий үзэл бодол нийлсэн бүлэг хүмүүсийн байгууллага юм. Улс төрийн хоёр гол намын төлөөлөгчид конгресст суудал эзэлж тус орны хууль тогтоомж, гадаад, дотоод бодлогын гол гогцоо асуудлаар байр сууриа хамгаалж иржээ.

АНУ-д улс төрийн гол намууд гишүүний тухай дүрэм горимгүйгээр аль намын үйл ажиллагааг дэмжиж байгаагаар нь гишүүн дэмжигч хэмээн үздэг. Ийм учраас аль ч нам нь хэд хичнээн гишүүдтэй гэж тооцоо гаргадаггүй ажээ.

Нэг намыг талархан дэмжигч нь тодорхой асуудлаар нөгөө намыг дэмжих явдал цөөнгүй. Ардчилсан намын хуучныг баримтлагч тал Бүгд Найрамдахчуудыг дэмжиж байхад Либерал бүгд найрамдахчууд Ардчилсан намыг дэмжих нь өрдийн үзэгдэл болсон ажээ.

Эдүгээ ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхөө гадаад, дотоод бодлогын асуудлаар хувь хүний эзлэх байр суурь голлодог болсон агаад намуудын үйл ажиллагааг хатуу зааглан тодорхойлох боломжгүй ажээ.

АНУ-ын эрх баригч 2 намын үндэсний конвенц (их хурал) 4 жилд 1 удаа

ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө болж тус намаас сонгуульд чухам хэний нэрийг дэвшүүлэхээ тодорхойлдог байна. Мужуудад намын удирдах хэсэг ажиллана. Тэдгээрээс Үндэсний комисс (Төв хороо) бүрэлддэг байна. Энэхүү үндэсний комиссын гол үүрэгт их хурлаа зохион байгуулах, түүний хэлэлцэх асуудал, хуралдах газрыг товлон ажил голлоно.

Үндэсний комисс ерөнхийлөгчийн сонгуулийн компаниг ажил, мөнгөн санхүү, олон нийтийн нухуулга, шинжилгээний ажил явуулдаг байна. Ардчилсан нам, Бүгд найрамдах намын аль алинаас нь муж улсуудад комиссууд ажиллаж, муж улсын конвенцийг зохион байгуулдаг байна. Нам бүх тойргуудад өөрийн комисстэй түүний дор хот, дүүрэгт үйл ажиллагаагаа явуулдаг. Тус бүрээ манлайлагчтай байна.

Түүгээр ч барахгүй Бүгд найрамдах, Ардчилсан нам хоёр үзэл баримтлал, улс орныг удирдах ерөнхий барилын хувьд зарчмын төдийлөн их ялгаагүй, үнэн чанартаа бараг нэг нам - ардчилсан бүгд найрамдах нам болж байна гэж зарим судлаачид бичдэг ажээ.

Намуудыг дэмжигч гишүүдийн бүрэлдэхүүний байдлаас авч үзвэл ардчилсан намын талд гол төлөв залуус, мөн нийгмийн доод давхаргад тооцогддог хар арьстан, эмэгтэйчүүдийн дийлэнх хэсэг нь саналаа өгч байхад хөрөнгө чинээ ихтэй баячуудын дийлэнх хэсэг нь Бүгд найрамдах намд саналаа өгдөг болжээ гэсэн дүгнэлтийг зарим судлаачид хийдэг үндэстэй байж болох юм.

Америкийн Нэгдсэн Улсын улс төрийн байгуулалт холбооны улсын засан тогтнох эрх зүй, түүний үйл ажиллагааны зарчим, ёс горимыг тодорхойлсон харьцангуй тогтвортой зохион байгуулалттай тогтолцоо юм. Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх засаглалын хувьд холбооны засаглал бүхий дэлхийн бусад засаглалын тогтолцоог бий болгохдоо америкийн засаглалаас жишээ эрэн авч судлах явдал ч цөөнгүй байна. Гэвч тухайн орны түүхэн онцлог, эдийн засгийн хүчин чадал, уламжлал, ёс заншил, шашин шүтлэг зэргээс улс бүр өөр өөрсдийн улс төрийн системийг хуульчлан тогтоож засан тохиуулах арга хэлбэрийг сонгож авч хэрэглэсээр байна.